



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/397

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн их засварын хөрөнгө оруулалтаар “Зөөлөн тэмүүлэл” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвийн засвар” ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: З.Өмиртай - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Б.Болортуул - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

З.Батзаяа - Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

М.Нансалмаа - “Шим-Ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер

Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга

Ц.Отгонзаяа - Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвийн дарга

У.Болдбаяр - “Зөөлөн тэмүүлэл” ХХК-ийн захирал


Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

8400 01 2021  
Zah A7397/Kh

2. "Зөөлөн тэмүүлэл" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн "Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвийн засвар" ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (З.Өмиртай)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



ДЭЛГЭРСАЙХАН